

Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр 2018:

Эрх мэдлийг хяналтандаа байлгах нь: Хэвлэл мэдээлэл, шударга ёс, хууль дээдлэх ёс

Үзэл баримтлалын баримт бичиг

Хураангуй

2018 оны Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрөөр 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэвлэл мэдээлэл, шүүх засаглал болон хууль дээдлэх ёсны уялдаа хамаарлын талаар олон талаас хэлэлцэнэ. Тавдугаар сарын 3-нд тэмдэглэн өнгөрүүлдэг энэ өдрийн үеэр хэвлэл мэдээллийн асуудлууд, улс төрийн үйл явцын ил тод байдал, шүүхийн тогтолцооны хараат бус байдал, мэдээллийн бичиг үсгийн боловсрол, төрийн байгууллагын олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын талаар мэтгэлцээн өрнүүлнэ. Энэ утгаараа, сонгуулийн зөрчил, жендэрт суурилсан тэгш бус байдал, Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ)-ыг дордуулахуйц хэмжээний хүний эрхийн зөрчлүүдийг илрүүлэхийн төлөө хараат бус сэтгүүл зүйн хүлээсэн хоточ нохойн үүргийг хэрхэн бэхжүүлэх талаар авч үзнэ. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тэр дундаа хүний суурь эрх болсон мэдээлэл олж авах эрхийг хангах, ялангуяа хэвлэлийн эрх чөлөөг хуулиар баталгаажуулж, хараат бус шүүхээр хамгаалсан орчин бүрдсэн цагт дээр дурдсан үүрэг биелүүлэх нөхцөл бүрдэнэ. Гэсэн хэдий ч эрх зүйн зохицуулалт цензурт хүргэх тохиолдол бий. Тухайлбал, интернэтэд, цахим үйлчилгээ үзүүлэгчдийн хариуцлагын асуудал нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангахад саад учруулж байна. Тиймээс энэ өдөр онлайн дахь хэвлэлийн эрх чөлөөний орчин үеийн сорилт бэрхшээлийг мөн нягтлан үзнэ. Цахим, уламжлалт аль ч хэвлэл мэдээллийн сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах нь эрх мэдлийг хараа хяналттай байлгахын урьдач нөхцөл мөн бөгөөд энэ нь ДХЭЧӨ-өөр анхаарал хандуулах асуудалд багтана.

Хүлээгдэж буй үр дүн

2018 оны ДХЭЧӨ-өөр дараах үр дүнд хүрэхээр тооцоолж байна. Үүнд:

- ТХЗ-ын 16 дугаар зүйлд заасан зорилтод хүрэх үүднээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрх, цахим, уламжлалт аль ч хэвлэл мэдээллийн сэтгүүлчдийн аюулгүй байдал зэргийг хангасан эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, засгийн газрууд, бусад байгууллага, хувь хүмүүс үүнийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагад анхаарал тавина.
- Хэвлэлийн эрх чөлөөг хамгаалахад онцгой хувь нэмэр оруулж, олон улсад хамгийн нэр хүндтэйд тооцогдох ЮНЕСКО-ийн Гильермо Каногийн нэрэмжит Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний шагнал хүртсэн тодорхой хувь хүн, байгууллагаар дамжуулан мэдлэг ойлголтыг дээшлүүлнэ.
- Дэлхий даяарх орон нутгийн төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн салбарынхан ДХЭЧӨ-өөр үндэсний хэмжээний 100 гаруй арга хэмжээг гардан зохион байгуулснаар Гана улсын Аккра хотноо зохиогдох гол арга хэмжээнд нэгдэж, хүч түрнэ.
- Латин Америк, Өмнөд болон Дорнод Африкт амжилттай хэрэгжүүлсэн санал санаачилгыг давтан, Баруун Африкт шүүгч, шүүхийн ажилтнуудад сэтгүүлчдийн аюулгүй байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх ЮНЕСКО-ийн сургалт зохион байгуулахад гол байгууллага, хувь хүмүүсийг татан оролцуулж, хамтран ажиллах санаачилга өрнөнө.
- Сэтгүүлчдийн аюулгүй байдлын асуудлаарх эрдэм шинжилгээний бага хурлаар дамжуулан

Сэтгүүлчдийн аюулгүй байдлын судалгааны сүлжээг бэхжүүлэн өргөжүүлнэ. Хэвлэл мэдээллийн хөгжлийн олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаа судалгааны үр дүнтэй нягт уялдана.

- Залуу сурвалжлагчид, сэтгүүл зүйн оюутан залуус хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангахад тулгарч буй саад бэрхшээл, мөн хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийн хүргэж буй олон улсын томоохон үйл явдлын шууд сурвалжлагаар дамжуулан өөрсдийн мэргэжлийн ур чадварын талаар шүүн тунгаана.
- НҮБ-ын Сонгуульд дэмжлэг үзүүлэх агентлаг хоорондын зохицуулалтын механизм (ICMEA)-ыг дэмжих үүднээс сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүргийн талаар сайн туршлага солилцоно.
- ДХЭЧӨ-ийг тохиолдуулан хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээ сурвалжлага, блог, цахим хуудсаараа дамжуулан хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн аюулгүй байдлын асуудалд идэвхтэй оролцоно.
- Хүний эрхийн болон урлагийн эрх чөлөөг хамгаалагч байгууллагууд хяналт шинжилгээ хийх чадвар, цахим эринд уран бүтээлчдийн төсөөлөн бодох, бүтээж туурвих, уран бүтээлээ цахимаар олон нийттэй чөлөөтэй хуваалцах эрхийг хамгаалах талаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах чадавх бэхжинэ.

Танилцуулга

ДХЭЧӨ-ийг тэмдэглэн өнгөрүүлэх санал санаачилга нь анх 1991 онд Намиби улсад баталсан хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийг хөхиүлэн дэмжих тухай Виндхукийн тунхаглалаас үүссэн юм. 2018 онд дэлхий нийтийн тэмдэглэлт үйл явдал анх эхлэл тавьсан тивдээ эргэн ирж байна. Энэ жил Гана улсын Аккра хотноо ЮНЕСКО-ийн удирдлага дор дэлхий нийтээр тухайн өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, түүний сэдвийг дэлхийн бусад улс оронд хэлэлцэнэ.

“Эрх мэдлийг хяналтандаа байлгах нь: Хэвлэл мэдээлэл, шударга ёс, хууль дээдлэх ёс” сэдвийн дор тэмдэглэн өнгөрүүлэх энэ жилийн ДХЭЧӨ-ийн үеэр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний өмнө тулгарч буй өнөөгийн сорилт бэрхшээл, ололт амжилтын талаар хэлэлцүүлэг өрнүүлж, энэ талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлнэ.

Энэ өдрийг НҮБ-аас 2015 онд батлан гаргасан бүх нийтээр тогтвортой хөгжилд хүрэх, тэр дундаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн 17 зорилт бүхий 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлнэ.

Дээрх зорилтууд дундаас ТХЗ-ын 16 дугаар зүйл нь шударга, амгалан тайван, бүх нийтийн оролцоог хангасан нийгмийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн. Энх тайван, шударга ёс болон хүчирхэг тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож, цаашид хараат бус, таатай орчин бүхий хэвлэл мэдээллээр тэтгүүлсэн тогтвортой хөгжлийн бусад хүчин чармайлтыг идэвхжүүлнэ.

Дэлхий дахинд улс төр, технологи, эдийн засгийн салбарт өрнөж буй өөрчлөлтийн улмаас хэвлэлийн эрх чөлөөний байдал улам хурцадмал болж байна. Зарим бүс нутагт төрөөс хязгаарлалт бүхий хууль тогтоомж, цензураар дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг боомилсон явдал гарлаа. Үндэсний аюулгүй байдлыг хангах, терроризмтэй тэмцэхтэй холбоотой шинэ тутам хязгаарлалтууд дээрх хандлагыг бэхжүүлж байна. Интернэтийг хаах зэрэг томоохон зөрчлүүд нэмэгдсээр¹ Мэдээллийн эх

¹UNESCO, World Trends in Freedom of Expression and Media Development: Global Report 2017/2018.

сурвалж хамгаалах тухай үндэсний хууль тогтоомж зөрчигдсөн тохиолдол мөн ажиглагдав.² Үүгээр ч үл барам, сэтгүүлчид ажлаа хийх явцдаа заналхийлэл, хүчирхийлэл, үзэн ядалтын шинжтэй үг хэллэг, сүрдүүлэг, тэр бүү хэл амь насаа алдах эрсдэлтэй байнга тулгарч буй нь улам түгшээж байна. Үүний зэрэгцээ, мэдээлэл олж авах эрхийн тухай хууль батлан гаргасан улс орны тоо тасралтгүй өссөөр байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Аюулгүйн зөвлөл, Хүний эрхийн зөвлөл болон ЮНЕСКО-оос батлан гаргасан тогтоолууд сэтгүүлчдийн, ялангуяа эмэгтэй сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах тухай олон улсын хэм хэмжээг дэмжин бататгав. Түүнчлэн хувийн нууцтай байх эрхийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрлөө.

“Эрх мэдлийг хяналтандаа байлгах нь: Хэвлэл мэдээлэл, шударга ёс, хууль дээдлэх ёс” сэдэв нь хэвлэлийн эрх чөлөөний эрх зүйн таатай орчин бүрдүүлэхийн чухлыг онцолж, хэвлэлийн эрх чөлөөг хуулиар хамгаалах, сэтгүүлчдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг баталгаажуулахад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаар бүрэн мэргэшсэн хараат бус шүүхийн ач холбогдолд онцгойлон анхаарна.

Ингэхийн сацуу тус сэдвээр дамжуулан тогтвортой хөгжил, эгэх хариуцлага, хууль дээдлэх ёсыг сахихад гүйцэтгэх хэвлэл мэдээллийн үүрэг, нэн ялангуяа түүний сонгуулийн үеэр ил тод байдлыг хангахад гүйцэтгэх хоточ нохойн үүргийн талаар онцолно. Түүнчлэн онлайн дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл олж авах эрхтэй холбогдох хуулийн цоорхой, онлайн орчинд үг хэлэх асуудлыг зохицуулахад гарах эрсдэлийг илрүүлнэ.

2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд энх тайван, шударга ёс, хүчирхэг тогтолцоо бий болгох тухай ТХЗ-ын 16 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмэр дээшилнэ. Энэхүү зорилгод хүрэхийн тулд үр нөлөө бүхий, хариуцлагатай, ил тод тогтолцоог бүх шатанд хөгжүүлэх шаардлагатай бөгөөд үүнд хэвлэлийн эрх чөлөө голлох үүрэгтэй.

2018 оны Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрөөр дараах дэд сэдвийг хөндөнө. Үүнд:

1. Хэвлэлийн эрх чөлөө, мэдээлэл олж авах эрх ба сонгууль
2. Чөлөөт, аюулгүй сэтгүүл зүйг дэмжсэн эрх зүйн тогтолцоо
3. Онлайн дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө: өөрийн зохицуулалтыг сайжруулах нь.

1. Хэвлэлийн эрх чөлөө, мэдээлэл олж авах эрх ба сонгууль

Хэвлэл мэдээллийн чөлөөт, олон ургальч орчин нь олон нийтэд илэрхийлэх боломж олгох улс төрийн хүсэл зоригийг бий болгож, сайн засаглалыг хөгжүүлэхэд түлхэц болдог. Тиймээс ардчилал, тогтвортой хөгжилд оруулах сэтгүүлчдийн гол хувь нэмэр бол улс төрчид, байгууллагуудын хариуцлагатай байдлыг хангах, тэдний хөтлөгч болох ардчилсан үйл явцад хяналт шинжилгээ хийж, мэдээлэх явдал юм. Олон нийтийн эрх ашгийн үүднээс нотолгоонд суурилсан мэдээллийг боловсруулж, түгээх хараат бус, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй нь жендэрийн харалган байдал, сонгуулийн зөрчил, харанхуйгаар шийдвэр гаргах явдалтай тэмцэх шилдэг арга болно.

Тухайлбал, эгэх хариуцлагын хэмжүүр болсон сонгуулийн шударга, зүй ёсны байдлыг гагцхүү жендэрийн

²Мөн тэнд

зохистой мэдрэмж бүхий үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл олж авах суурь эрх, эрх чөлөөгөөр дамжуулан хангах боломжтой. Санал хураах үйл явцтай холбогдох хуульд нийцэж буй эсэхэд хяналт шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлснээр чөлөөт хэвлэл нь хууль дээдлэх ёсыг баталгаажуулж буй нь шүүхийн гүйцэтгэх үүрэгтэй ижил төстэй. Шүүмжлэлт мэдээ, сурвалжлагаар дамжуулан улс төрийн сонгуульд нэр дэвшигчдийн ажлын үзүүлэлтийн талаар мэдээлэл түгээнэ.

Хараат бус, жендэрийн мэдрэмжтэй сурвалжлага нотолгоонд суурилсан мэдээллээр олон нийтийг хангаснаар иргэний оролцоог нэмэгдүүлнэ. Гэсэн хэдий ч улс төрийн үйл явц дахь хэвлэл мэдээллийг сонгогчдыг хууран мэхлэхэд ашиглах үзэгдэл гарч байна. Сүүлийн үеийн жишээнээс харахад, үүнд хувийн, төрийн оролцогчдын аль аль нь, мөн хэвлэл мэдээллийн эзэд оролцсон тохиолдол гарсан. Мэдээний хэвлэл мэдээллийн хэрэгслийг улс төрийн төлөв байдалд нөлөөлөх зорилгоор шударга бус мэдээ, сурвалжлага хүргэсэн хэмээн буруутгасан. Мөн олон нийтийг төөрөгдүүлэх, жинхэнэ сэтгүүл зүйн нэр хүндийг гутаах зорилгоор нийгмийн сүлжээ ашиглан хуурамч мэдээ түгээсэн томоохон оролдлогууд гарлаа. Энэ мэт саад бэрхшээл нь хараат бус, шүүмжлэлт, олон ургальч хэвлэл мэдээллийн орчин бий болгохын ач холбогдлыг ойлгуулж, чөлөөт, мэргэжлийн сэтгүүл зүйн эрэлт хэрэгцээг тодоор харуулж байна.

Сонгуулийн үеэр болон сонгуулиас гаднах эрэн сурвалжлах мэдээ сурвалжлага нь төрийн албан хаагчийг сониуч хэвлэл мэдээлэлтэй танил болгосноор мэдээлэл нээлттэй байх соёл төлөвшүүлэхэд дөхөмтэй. Мэдээллийн хүртээмжтэй байдал мөн хэвлэл мэдээллийн хоточ нохойн үүргээ гүйцэтгэх боломж бүрдүүлэх урьдач нөхцөл болно. Цаашлаад ил тод байдал төрийн бодлогын талаарх илүү ойлголт өгснөөр олон нийтийг хүчирхэгжүүлэх, улс төрийн үйл явцын үр нөлөөг дээшлүүлэх, авлигатай тэмцэхэд хувь нэмэр оруулна. Сүүлийн 10 гаруй жилийн турш нийт 111 орон төрийн баримт бичгийг ил тод байлгах талаар бодлого шийдвэртээ тусгаж, сүүлийн дөрвөн жилийн хугацаанд 15 оронд эдгээр хууль тогтоомж хүчин төгөлдөр боллоо.³ Улс төрийн зүгээс ил тод байдлыг ингэж хүлээн зөвшөөрсөн явдал нь сайн засаглалын анхдагч чухал нөхцөл бөгөөд хууль дээдлэх ёсыг сахин хамгаалахад амин чухал.

Гэсэн хэдий ч хуулийн дагуух мэдээллийн хүртээмжтэй байдал нь олон нийтийг, нэн ялангуяа эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхгүй, эрх мэдэлтнүүдийг ч хариуцлагатай болгохгүй. Түүнийг хүртээмжтэй байлгаж, олон нийтэд хүргэх шаардлагатай. Нэг талаараа хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм уншигчдад зориулан мэдээлэлд дүн шинжилгээ хийж нэгтгэх, олон нийтийн анхааралд авчрах, нөгөөтэйгүүр хэвлэл мэдээлэл, мэдээллийн бичиг үсгийн боловсролыг дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой. Нийгмийн сүлжээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь мэдээллийн эрх чөлөө, ил тод байдлыг хангах замаар эерэг өөрчлөлт авчрах идэвхтэй тэмцэгч байж чадна. Чөлөөт сэтгүүлч, хараат бус хэвлэл мэдээлэл нь хариуцлага бий болгох, эрх мэдлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай тэдний дээрх хөдөлгөөнийг дэмжих суурь эрх чөлөөг хангана.

2. Чөлөөт, аюулгүй сэтгүүл зүйг дэмжсэн эрх зүйн тогтолцоо

Шударга, үр нөлөө бүхий, хараат бус шүүхийн ажиллагаа нь ардчилсан бусад бүх тогтолцооны тулгын чулуу болсноор хууль дээдлэх ёс хэрэгжинэ. Тэртээ гурван зууны өмнө Монтеस्कьегийн хэлснээр, шүүх

³UN, The Sustainable Development Goals Report

2017<https://unstats.un.org/sdgs/files/report/2017/TheSustainableDevelopmentGoalsReport2017.pdf>

эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс тусгаарлаагүй тохиолдолд эрх чөлөө үл оршино.⁴ Хараат бус шүүх эрх мэдэл ардчиллыг улам бэхжүүлж, нийгмийн бүх оролцогч талуудыг хүчирхэгжүүлдэг. 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оруулах хэвлэл мэдээллийн оролцоог дээшлүүлэх үүднээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл олж авах эрх, сэтгүүлчдийн аюулгүй байдал зэрэг нь шүүхээр, хууль хэрэгжүүлэгч талуудаар бүрэн хамгаалагдвал зохих эрх мөн.

Энэ утгаараа, шүүгч, шүүхийн ажилтнуудын чөлөөт, хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийн орчин бүрдүүлэхэд гүйцэтгэх үүрэг асар чухал. Шүүх эрх мэдэлд энэ эерэг үүргээ биелүүлэх боломж олгохын тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үндэслэлгүйгээр боомилохын оронд, хамгаалах шаардлагатай. Дэлхийн зарим хэсэгт нэр төр гутаахтай холбоотой хууль зэрэг нь сэтгүүлчдийн үйл ажиллагаанд саад хийдэг ч шүүгчдэд “гэмт хэрэг”-ийн “хэм хэмжээндээ байх” явдлыг тайлбарлах боломж байдаг. Түүнээс гадна, шүүхийн ажилтнууд хэвлэл мэдээллийн талаар анхдагч мэдэгдэхүүн эзэмшсэн байх, хэвлэлийн эрх чөлөө нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тэр дундаа цахим орчинд, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбогдох өргөн хүрээний асуудалтай уялдаа холбоотой гэдгийг ойлгох нь чухал.

Шүүхийн ажилтнууд олон улсын хэм хэмжээ, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай бүс нутгийн хууль эрх зүйн талаар мэдлэгтэй болсон цагт шүүх эрх мэдэл нь хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалж чадна. Шүүхийн ажилтнууд хуулиар тогтоосон тодорхой удирдамжийг даган мөрдөж, үг хэлэх эрхийг дур зоргоор түдгэлзүүлэх зэрэг шударга бус үйлдлээс сэргийлж болно. Дээрх үүргийг хүлээн зөвшөөрсний улмаас ЮНЕСКО 2014 оноос эхлэн Латин Америкт 5000 гаруй шүүгч, шүүхийн ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байна. Энэхүү санаачилгыг өдгөө Африкт даган хэрэгжүүлэхдээ, Африкийн Хүний болон Ард түмний Эрхийн Шүүхтэй хамтран, Дорнод болон Өмнөд Африкийн шүүгчдэд голлон анхаарч байна.

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага нь хуулийн хариуцлагад татах хэмжээний халдлагад өртсөн тохиолдолд шүүхийн ажилтнууд хүчний байгууллагуудтай хамтран хариу үйлдэл үзүүлснээр сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангахад гол үүрэг гүйцэтгэнэ. ЮНЕСКО-ийн бүртгэснээр 2006-аас 2016 оны хооронд 929 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан бусдад хорлогдон амь насаа алдсан ба эдгээр хэргийн дийлэнхэд буруутан ял шийтгэлгүй үлдсэн байдаг. Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдлийг ял шийтгэлгүй үлдээх нь өөрийн цензурт хүргээд зогсохгүй, олон нийт өөрийгөө илэрхийлэх эрх чөлөө бүхий нээлттэй нийгэм оршин тогтнох аргагүй болно. Прокурор сэтгүүлчдэд халдсан этгээдийг шүүх явцад шүүхийн шийдвэрийг бататгаснаар үг хэлэх эрх чөлөөг хамгаалах талаар олон нийтэд хүчтэй дохио өгөх боломжтой.

Шүүх эрх мэдлээс гадна, сэтгүүлчдийн аюулгүй байдал, тэдний эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд олноороо ял завших асуудалд бусад талууд анхаарал хандуулахад голлон оролцоно. Энэ хүрээнд ЮНЕСКО нь Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буй асуудлаарх НҮБ-ын төлөвлөгөө (цаашид НҮБ-ын төлөвлөгөө гэх)-г түгээн дэлгэрүүлж байна. Тус байгууллага 2012 оноос хойш уг асуудлаар бүх оролцогч талын үйл ажиллагааг зохицуулах цар хүрээг тодорхойлсон. 2017 оны долдугаар сард болсон олон талт хэлэлцүүлгийн үр дүнд НҮБ-ын төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах талаар тодорхой санал дэвшүүлсэн. Үүний дотор шүүгч, прокурор, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын чадавхийг бэхжүүлэх, бусдад хорлогдон

⁴ Montesquieu, *The Spirit of the Laws*, 1748.

амь насаа алдсан сэтгүүлчдийн хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, мэдээлэхэд анхаарал хандуулна.

3. Онлайн дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө: өөрийн зохицуулалтыг сайжруулах нь

Цахим эринд онлайн өгөгдөл нь мэдээлэл харилцаа, сэтгүүл зүй, зар сурталчилгаа, бодлого боловсруулах, дипломат харилцаанд шинэ эргэлтийг бий болгосон.

Интернэтийн нээлттэй байдал нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлдэг боловч түүнд саад бэрхшээл тулгарч байна. Үзэн ядалтын шинжтэй үг хэллэг, сүрдүүлэг заналхийлэл, хувийн мэдээлэл алдагдах зэрэг асуудал нь интернэтийн хэрэглэгч бүрт сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулсан аюулт үзэгдэл юм. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд онлайн орчинд ажиллахдаа эдгээр эрсдлээс, ялангуяа эх сурвалжийн нууцлалтай холбогдсон тохиолдолд зайлсхийх нь зүйтэй. Нийгмийн сүлжээ ба хүчирхийлэл дагуулсан бодит радикалчлалын хооронд шууд уялдаа холбоо бий гэх нотолгоо хомс ч интернет нь хүчирхийлэл дагуулсан экстремистүүдийн ухуулга суртлаа дэлгэрүүлэх талбар хэмээн ойлгогдох болов. Энэ нь илэрхийлэх эрх, хувийн нууцтай байх зэрэг эрхийг хангахад сөрөг үр дагавар бий болгоно.

Эдгээр эрсдлийг бууруулахдаа Засгийн газрууд, бусад бүх байгууллага, хувь хүмүүсийн үйл ажиллагаа нийгэмд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдээс гадна ЮНЕСКО-ийн Интернэтийн түгээмэл үзэл баримтлал дахь Интернэтийн R.O.A.M (*Rights based, Openness, Accessibility, Multi-stakeholder participative*) хүний эрхэд суурилсан, нээлттэй, хүртээмжтэй, олон талын оролцоонд суурилсан зарчимд нийцэхүйц эрх зүйн орчны тусламжтайгаар онлайн дахь аюул заналтай тэмцэхэд чиглэх ёстой.

Интернэтийн томоохон компаниуд хэрэглэгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэнэ. Контент устгах, хэрэглэгчийн өгөгдөлд нэвтрэх зэрэг Засгийн газрын хүсэлт шаардлагын талаарх мэдээлэл тайлангийн ил тод байдалд ахиц гарсан хэдий ч компанийн дотоод хэв маяг, өмчийн алгоритмын тухай асуудал тодорхой бус хэвээр байна. Түүнчлэн, интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн үзүүлж буй үйлчилгээ хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувийн нууц, зохих ёсны процедурыг хангалттай хамгаалж чадахгүй байна. Тэдгээрийг гол төлөв хэт өргөн утгаар ашигладаг ба хохирол барагдуулах тодорхой, үр дүнтэй арга хэмжээ авахгүй байсаар байна.

Интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн өөрийн зохицуулалтын бүтэц сул, санхүүжилт хомс зэрэг байдал нь хууль тогтоомж, дүрэм журмыг олноор батлагдахад хүргэсэн. Үүнтэй холбоотой шүүхийн шийдвэрүүд, мөн хожим батлагдах хууль тогтоомжийн үндэс суурь болж байна. Хэвлэлийн эрх чөлөөнд шууд нөлөөлөхүйц сүүлийн үеийн жишээ баримтаас “мартагдах эрх”, “жагсаалтаас хасагдах эрх”, хилийн чанад дахь өгөгдлийн урсгал, интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн үүрэг хариуцлагын тухай шүүхийн шийдвэрүүдийг дурдаж болно. Тиймээс интернэт дэх эрхийн талаарх хууль тогтоомжийг боловсруулахад шүүхийн дээрх сайн жишээг орхигдуулж үл болно.

Чөлөөт илэрхийллийн үүднээс авч үзвэл, ихэнх тохиолдолд хууль тогтоомж хэт олширвол дутуу байхаасаа их асуудал дагуулдаг. Онлайнгаар контент түгээж буй хэвлэл мэдээллийн байгууллага ба гуравдагч этгээдийн бүтээсэн контентийг байршуулсан интернэт платформын үүрэг хариуцлагын ялгааг олон хуульд тодорхойлоогүй орхисон. Ийм хууль эдгээр платформыг зохих хэмжээнээс хэтэрсэн шийтгэл хүлээлгэх айдас дунд дэг журам сахиулах үүрэг гүйцэтгэж эхэлдэг. Үүний үр дүнд платформууд

маргаан дагуулсан аль ч контентийг алгоритмын тусламжтайгаар эсхүл хүний оролцоотойгоор хамгийн амар, хямд арга болох устгах арга хэмжээ авахаас гадна хэрэглэгчийн өгөгдлийг зохих ёсны процедурыг үл харгалзан бусдад дамжуулах хандлагыг нэмэгдүүлж байна. Энэ процессын явцад үзэл бодлын хууль ёсны илэрхийлэл нь цензурыг хувь этгээдийн хараа хяналтад оруулсны золиос болдог.

Контент үйлдвэрлэгчдийг хуулийн хариуцлагад татах явцаас бусдын анхаарлыг сарниулах, интернэтийн үйлчилгээ хүртэгчдийг чадавхжуулахуйц үндэсний хэвлэл мэдээлэл, мэдээллийн анхдагч мэдэгдэхүүний талаар баримтлах бодлогын хэрэгцээ шаардлагаас зайлсхийх үүднээс платформуудыг золигт гаргаж байна. Энэ утгаараа өөрийн зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах тулгуур болно.

Сүүлийн үед ардчилсан улс орнуудад хүртэл интернэтийн үйлчилгээнд хөндлөнгөөс оролцох явдал олширч байна. “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хэвлэл мэдээллийн хөгжлийн дэлхийн чиг хандлага” Дэлхийн 2017-2018 оны тайланд мэдээлснээр, контент шүүх, вебсайт блоклох, интернэт хаах үйлдэл өсөн нэмэгдэж, ихэнх тохиолдолд хуулийн үндэслэл тодорхой бус байв. Интернэтийн үйлчилгээ, цахим харилцаанд санаатай нөлөөлөх нь мэдээллийн урсгалд хяналт тавих нийтлэг арга хэмжээ юм. Мөн чанартаа, цензурыг бүрэн утгаар нь хэрэгжүүлдэг. Үүнийг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Үзэл бодлын асуудлаарх Тусгай илтгэгчид, Африкийн комисс, Онлайн эрх чөлөө эвслээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрхийг үндэслэлгүйгээр хязгаарласан үйлдэл гэж үзсэн. Төрийн болон бизнесийн байгууллагын DoS халдлага (*серверийн ажиллагааг зогсоож улмаар Database руу нь нэвтрэх. Орч.*), цензур зэрэг нь онлайн дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөөг боомилоход түлхэц болно.

Онлайн дахь суурь эрх чөлөөг баталгаажуулахад олон талт хандлага шаардлагатай. Энэ нь ЮНЕСКО-ийн Интернэтийн түгээмэл үзэл баримтлал, түүний R.O.A.M зарчмуудын шалгуур үзүүлэлтүүдийг дэмжин хөгжүүлэх хүчин чармайлтын нэг юм. Ингэснээр онлайн дахь илэрхийлэл, хувийн нууцын өөрийн зохицуулалтын бүтцийг бэхжүүлэхэд түлхэц болохын зэрэгцээ харилцан хамаарал бүхий интернэтийн R.O.A.M хэмжүүрт сөргөөр нөлөөлөхүйц зохицуулалтын арга хэмжээг хараа хяналттай байлгахад тустай.

Эцэст нь тэмдэглэхэд, “Соёлын бодлогыг дахин тодорхолох нь” ЮНЕСКО-оос эрхлэн гаргасан Дэлхийн тайланд мэдээлсэнчлэн, шинэ тутам цахим технологи, тэр дундаа нийгмийн сүлжээний талбар нь урлагийн ертөнц рүү шилжиж байна. Инстаграм, Саундклауд зэрэг нийгмийн сүлжээ, дуу хөгжим дамжуулах сувгууд уран бүтээлчдийн өөрсдийн бүтээлээ толилуулах, таниулан сурталчлах талбар болж байна. Гэвч тэднийг дагаад эрх, эрх чөлөөнд аюул занал учирч байна. Үүний дотор бусад хэрэглэгчдийн сүрдүүлгээс улбаалан уран бүтээлчид бүтээлээ эгүүлэн татахад хүргэхүйц цахим орчин дахь дарамтыг нэрлэж болно.

Өсөн нэмэгдэж буй цахим мөрдөн тагнах ажиллагаа урлагийн эрх чөлөөнд сөргөөр нөлөөлж байна. Ихэнх платформын хувьд “зан байдал”-ын талаарх Инстаграмын удирдамж гэх мэт өргөн утгаар нь ойлгон, тайлбарлах боломж бүхий механизм нэвтрүүлсэн. Энэ нь эргээд урлагийн бүтээлийн контент санаад нь нийцээгүй байгууллага, хувь хүмүүст зохисгүй эрх мэдэл өгч, платформын мэдээлэх журмыг ашиглан хувь хүмүүсийн урлагийн бүтээлийг устгах, зарим тохиолдолд аккаунтыг нь блоклох хүртэл арга хэмжээ авахад хүргэдэг. Уран бүтээлчдийн хувьд ийм төрлийн онлайн ажиллагаа нь санаа бодлын урсгалд саад хийхээс гадна тэдний уран бүтээлийн эрх чөлөөг боогдуулж, олон түмэнтэй холбогдох боломжийг хаадаг. Уран бүтээлээ толилуулах гол арга хэрэгсэл хаагдахад уран бүтээлч хүн бусадтай

харилцах аргагүй болдог. 2018 оны ДХЭЧӨ нь эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шинэ санал дэвшүүлж, олон нийтийн мэдээлэл авах эрх, суурь эрх чөлөөг хамгаалах тухай Тогтвортой хөгжлийн 16 дугаар зорилтыг хөхиүлэн дэмжинэ.

Дүгнэлт

2018 оны Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг бүх нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх Аккра хотноо дэлхийн болон бүс нутгийн хэвлэл мэдээлэл, засгийн газар, иргэний нийгэм, судалгаа шинжилгээний байгууллагын төлөөлөл цугларна. Дэлхий даяар зохион байгуулах Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулсан арга хэмжээний үеэр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний өмнө тулгарч буй сорил бэрхшээл болоод шударга, амар амгалан, бүхнийг хамарсан нийгмийг цогцлооход гол хүчин зүйл болсон сэтгүүл зүйг бэхжүүлэх арга замын талаар хэлэлцэнэ. Ингэснээр 2018 оны сэдэв 100 гаруй оронд цуурайтах юм. Үйл явдлын үр дүнд дэлхий даяар хэвлэлийн эрх чөлөөний өмнө тулгараад байгаа шинэ тутам саад бэрхшээлийг даван туулахад оролцогч талуудын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх боломж олгоно.